



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Төлөвлөгөө баталж, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIII.1.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2022 оны бараа худалдан авах төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Хавсралтаар баталсан “Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2022 оны бараа худалдан авах төлөвлөгөө”-ний XIII.1.3.10.13, XIII.1.3.10.14 дүгээр төсөл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, зарцуулах эрхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төсвийн шууд захирагчид, бусад төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга /Х.Улам-Өрнөх/-д тус тус шилжүүлсүгэй.

3.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, явцын мэдээлэл, үр дүнг улирал тутам танилцуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210065

Боловсрол, шинжлэх ухааны Сайдын
2022 оны 01 дүгээр сарын 26 өдрийн
А/23 дугаар тушаалыг хавсралт

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН 2022 ОНЫ БАРАА ХУДАЛДАН АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хуулийн дугаар	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг /сая.төг/	Тухайн онд санхүүжих нь	Эрх шилжүүлэх эсэх	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Төндөр зарлах огноо	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9
	XIII.1.3.10.	Тоног төхөөрөмж	15,000.0	15,000.0				
Боловсролын салбарын /2022 онд шинээр ашиглалтанд орох Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад худалдан авах бараа/								
1	XIII.1.3.10.1	Ерөнхий боловсролын сургуульд сурагч ширээ, сандал, самбар, багшийн ширээ, сандал, бичгийн шүүгээ худалдан авах	4,500.0	4,500.0	ТХААГ	Ерөнхий гэрээ	2022.02.15	
2	XIII.1.3.10.2	Ерөнхий боловсролын сургуульд "Гал тогооны тоног төхөөрөмж" худалдан авах	1,000.0	1,000.0	ТХААГ	НТШ	2022.02.15	
3	XIII.1.3.10.3	Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд техник хэрэгсэл худалдан авах	1,000.0	1,000.0	ТХААГ	НТШ	2022.02.15	
4	XIII.1.3.10.4	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Гал тогооны тоног төхөөрөмж" худалдан авах	500.0	500.0	ТХААГ	НТШ	2022.02.15	
5	XIII.1.3.10.5	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхдийн ширээ, сандал, хувцасны шүүгээ, тоглоомын тавиур, гал тогооны шүүгээ, вандан сандал, багшийн ширээ, сандал, бичгийн шүүгээ, эрхлэгчийн ерөөний ширээ, сандал, бичгийн шүүгээ худалдан авах	1,000.0	1,000.0	ТХААГ	Ерөнхий гэрээ	2022.02.15	
Нийт төсөв								
Боловсролын салбар			8,000.0	8,000.0				
6	XIII.1.3.10.6	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Багш хөгжлийн төв"-ийн тоног төхөөрөмж худалдан авах	500.0	500.0	ТХААГ	НТШ	2022.02.15	
7	XIII.1.3.10.7	Ерөнхий боловсролын сургуульд "Байгалийн ухаан"-ы лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах	4,000.0	4,000.0	ТХААГ	НТШ	2022.02.15	
8	XIII.1.3.10.8	Ерөнхий боловсролын сургуульд үндэсний хөгжмийн хичээлийн хэрэгсэл худалдан авах	800.0	800.0	ТХААГ	НТШ	2022.02.15	

9	XIII.1.3.10.9	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад дуу хөгжмийн хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авах	500.0	500.0	ТХААГ	НТШ	2022.02.15
10	XIII.1.3.10.10	Тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	200.0	200.0	ТХААГ	НТШ	2022.02.15
11	XIII.1.3.10.11	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Гэр цэцэрлэг" худалдан авах	500.0	500.0	ТХААГ	НТШ	2022.02.15
Нийт төсөв			6,500.0	6,500.0			
Шинжлэх ухааны салбар							
12	XIII.1.3.10.12	Эрдэм шинжилгээний ажилтанд өндөр хүчин чадалтай суурин болон зөөврийн компьютер худалдан авах	250.0	250.0	ТХААГ	НТШ	2022.02.15
Бусад			250.0	250.0			2022.02.15
13	XIII.1.3.10.13	Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	100.0	100.0	БШУЯ	НТШ	2022.02.15
14	XIII.1.3.10.14	Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хэрэгцээнд шаардлагатай суурин болон зөөврийн компьютер худалдан авах	150.0	150.0	БШУЯ	НТШ	2022.02.15
Нийт төсөв			250.0	250.0			

.....000.....